

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

ОРШИЛ

Дэлхийн улс орнууд үндэсний баялгийн сангийнхаа хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд компанийн нэгдэл эсхүл хөрөнгө оруулалтын менежментийн компани болон банкаар (төв банк, хөрөнгө оруулалтын банк) дамжуулан удирдах хэлбэрийн аль нэгийг сонгож байна.¹ Баялгийн сангийн мөнгөн хөрөнгийг компанийн нэгдлийн хэлбэрээр удирдан хөрөнгө оруулалтын янз бүрийн арга хэрэгслээр амжилттай өсгөн нэмэгдүүлж буй жишээнд Сингапур Улсын “Темасек Холдинг”, БНХАУ-ын “Хөрөнгө Оруулалтын Корпорац”-ийг тус тус нэрлэж болох юм.

Манай улсын хувьд ч дээрх олон улсын сайн туршлагад тулгуурлан үндэсний баялгийн сангийн бүрэлдэхүүн болох Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагын хэлбэрийг компанийн нэгдлийн загварчлалаар хэрэгжүүлэхийг зорьж, “Хөгжлийн сангийн тухай” хуулийн төсөл боловсруулсан байна.

ЕРӨНХИЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

Хөгжлийн сангийн хууль бусад хууль тогтоомжтой нийцэх байдал

Бодлогын уялдаа холбоо, нийтлэг зарчим, түүний хэрэгжилтийг хангах үүднээс Үндэсний баялгийн сангийн хууль тогтоомж болон хуулийн үйлчлэх хүрээг шинээр батлагдах бусад холбогдох хуулийн төслүүдтэй уялдуулан тодорхойлох шаардлагатай байна.

Санал:

- Төрийн болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төслийн ТӨК-ийн удирдлага, зохион байгуулалттай холбоотой заалтуудыг Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагатай холбоотой зохицуулалттай уялдуулан давхцал, зөрүүг арилгах.
- Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийн зохицуулалттай Хөгжлийн сангийн ил тод байдал, тайлагналын зохицуулалтыг уялдуулан давхцал, зөрүүг арилгах.
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн төрийн өмчийн ангилал, төрийн өмчийн эрх зүйн байдлын зохицуулалтыг Хөгжлийн сангийн хуулийн төслийн холбогдох зүйл заалттай уялдуулан давхцал, зөрүүг арилгах.

¹ Үндэсний баялгийн сангийн институтын (SWFI) судалгааг <https://www.swfinstitute.org/fund-rankings/sovereign-wealth-fund> цахим хуудаснаас үзнэ үү.

Нэр томъёог оновчтой болгох

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д хөгжлийн санг төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр тодорхойлсон нь оновчгүй, бас хангалттай бус байна. Иймд хөгжлийн сан байгуулах зорилго, үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан түүнийг оновчтой тодорхойлж, хуулийн төслийн нэр томъёоны хэсэгт тусгах нь зүйтэй.

Санал: Хуулийн төслийн 4 дүгээр зүйл “Нэр томъёоны тодорхойлолт” хэсэгт дараах агуулгатай заалт нэмэх.

- 4.1.7. “*хөгжлийн сан* гэж газрын хэвлийн баялгийн үр өгөөжөөс өөрт ногдсон хэсгийг идэвхтэй хөрөнгө оруулалтын стратегийн дагуу удирдах, уул уурхайн салбарт дотоодод хэрэгжих төсөл, эрчим хүчний шинэ шийдлүүдийг хөгжүүлэх төрийн өмчит компаниудад санхүүгийн үр ашигтай хөрөнгө оруулалт хийх замаар өөрийн хөрөнгийг арвижуулан үндэсний баялгийн санд төвлөрүүлэх зорилго бүхий санг”;
- 4.1.8. “*хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч* гэж хөгжлийн санг удирдах компанийг”;
- 4.1.9. “*хөрөнгийн удирдлагыг мандатаар хэрэгжүүлэгч бусад этгээд* гэж тухайн салбарын мэргэшсэн оператор, хөрөнгө оруулалтын менежментийн компани болон бусад оролцогчийг тус тус ойлгоно”.

Хөгжлийн сангийн хөрөнгө

Хуулийн төслийн 6 дугаар зүйлд Хөгжлийн сангийн хөрөнгийг хэт явцуу хүрээнд буюу зөвхөн хувьцаа эзэмшигч (Засгийн газар)-ийн шийдвэрээр тогтоохоор байна. Гэтэл Хөгжлийн сангийн явуулж буй үйл ажиллагаатай холбоотойгоор түүний хөрөнгө нь олон төрөлтэй байж болох юм.

Санал: Хуулийн төслийн 6.1-ийг дараах байдлаар өөрчлөх:

- 6.1. Хөгжлийн сангийн хөрөнгө нь мөнгөн хөрөнгө, үнэт цаас, үл хөдлөх хөрөнгөөс бүрдэнэ.
 - 6.1.1. Хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгө нь сангийн үйл ажиллагааны үр дүнд хуримтлагдсан ашиг, үнэт цаасыг арилжсанаас олсон орлого, хувьцааны ногдол ашиг, үл хөдлөх хөрөнгийг бусдад ашиглуулсан, түрээслүүлснээс олсон орлогоос бүрдэнэ.
 - 6.1.2. Хөгжлийн сангийн үнэт цаас нь сангийн эзэмшлийн хувьцаа, өрийн хэрэгсэл, үүсмэл үнэт цаас болон бусад санхүүгийн хэрэгслээс бүрдэнэ.
 - 6.1.3. Хөгжлийн сангийн өмчлөлийн үл хөдлөх хөрөнгө нь дэд бүтцийн чиглэлээр өмчилж буй үл хөдлөх хөрөнгө, бусад үл хөдлөх хөрөнгөөс бүрдэнэ.

Хөгжлийн сангийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх

Хуулийн төслийн 10 дугаар зүйлд Хөгжлийн сангийн зардалд хөндлөнгийн аудит болон хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компаниас авсан үйлчилгээний зардлыг багтааж бусад зардлын санхүүжилтийг тодорхойгүй үлдээсэн байна.

Санал:

- Хөгжлийн сангийн зардлыг санхүүжүүлэхэд сангийн хөрөнгө болон сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч компанийн хөрөнгийн бүртгэл тооцоо тусдаа байх зарчим баримтлах.
- Сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч компанийн өдөр тутмын үйл ажиллагааны болон хөндлөнгийн аудитын зардал, хөрөнгө оруулалтын менежментийн компаниас авсан үйлчилгээний зардлыг Засгийн газраар батлуулж, зарцуулалтад аудит хийлгэн олон нийтэд танилцуулдаг байх.

Хараат болон охин компани

Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх компанийн хараат болон компани байгуулахтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулах нь зүйтэй.

Санал: Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч компани нь дараах үүрэгтэй ажиллах. Үүнд, Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалттай хувьцаат болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үнэт цаасыг хуульд заасан шаардлагын дагуу үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагад Хөгжлийн сангийн нэр дээр бүртгүүлэх, Хөгжлийн сангийн нэр дээр бүртгэлтэй үнэт цаасыг түүний хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч компанийн охин, хараат компанид арилжихыг хориглох нь зүйтэй.

Хөгжлийн сангийн хувьцаа эзэмшигч

Олон улсад баялгийн сангийн хөрөнгө ард түмэн, төрийн мэдэлд байх, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч компанийн хувьцааг төрийн байгууллага (Засгийн газар, Сангийн яам) эзэмших жишиг нийтлэг үйлчилдэг. Гэтэл хуулийн төслийн 14.1-д “Засгийн газар Хөгжлийн сангийн хувьцаа эзэмшигч байна” гэж томьёолсон нь оновчгүй байна.

Санал:

Хуулийн төслийн 14.1-ийг “Засгийн газар Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгчийн хувьцааг эзэмшинэ” гэж өөрчлөх.

Хуулийн төслийн 14-т доорх агуулга бүхий зохицуулалтуудыг нэмэх:

- Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч нь аливаа хэлбэрээр хувьцаанд хөрвөх үнэт цаас, давуу эрхийн хувьцаа, өрийн хэрэгсэл гаргах болон нэмж хувьцаа гаргахыг хориглоно.
- Засгийн газар нь Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгчийн хувьцааг (хувьцаа эзэмшигчийн эрхийг) төрийн бусад байгууллагад шилжүүлэхийг хориглоно.
- Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч толгой компанийн хувьцааг аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэх буюу эзэмшүүлэх, захиран зарцуулах, нээлттэй болон хаалттай хүрээнд арилжаалахыг хориглоно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг есөн хараат бус гишүүнтэй байхаар тусгажээ. Ийнхүү ТУЗ-ийн бүх гишүүн “хараат бус гишүүн” байх нь тэдний шийдвэр үр нөлөөтэй байх, шуурхай хэрэгжиж чадах эсэхэд нөлөөлөх эрсдэлтэй. Тэрчлэн ТУЗ-ийн гишүүнд оногдуулах хариуцлагаас шалтгаалан бодлогын шийдвэр гаргахтай холбоотой ТУЗ-ийн чадамж харьцангуй сул байх зэрэг сөрөг талтай.

Санал:

Хуулийн төслийн 15 дугаар зүйлд дараах агуулга нэмэх:

- Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгчийн төлөөлөн удирдах зөвлөл нь есөөс доошгүй гишүүнтэй байх бөгөөд нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүн байна.
- Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгчийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь Ерөнхий сайд байна.
- Сангийн сайд, Уул уурхайн сайд нь хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороо

Хуулийн төсөлд ТУЗ-ийн дэргэдэх хорооны үйл ажиллагааны чиглэл, ажиллах журмыг тодорхой тусгаагүй байна. Иймд аудитын хороогоор дамжуулан хяналтын механизмыг хэрхэн ажиллуулах гэх мэт хороодын үйл ажиллагааны зохицуулалтыг тодорхой болгох нь зүйтэй бөгөөд ТУЗ-ийн дэргэд нэр дэвшүүлэх хороог заавал байгуулах шаардлагыг нэмж тусгах нь зүйтэй.

Санал:

- Хуулийн төслийн 18.1-ийг “Төлөөлөн удирдах зөвлөл дараах хороог заавал байгуулна” гэж өөрчлөх.
- Хуулийн төслийн 18.1.4-г “Нэр дэвшүүлэх хороо” гэж шинээр нэмэх.

Хөрөнгийн удирдлагыг мандатаар гүйцэтгэх хуулийн этгээд (Хөрөнгө оруулалтын менежментийн компани)

ТУЗ нь мандатаар гүйцэтгэх хуулийн этгээдээр (хөрөнгө оруулалтын менежментийн компани) дамжуулан хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр гаргасан тохиолдолд хэрхэн хяналт тогтоох тухай зохицуулалтыг тусгах нь зүйтэй. Тухайлбал, хөрөнгө оруулалтын менежментийн компанитай байгуулах гэрээний нийтлэг зарчим (гэрээг цуцлах, өөрчлөх эрх, сангийн удирдлага давуу эрхтэй оролцох нөхцөл гэх мэт) зэргийг хуулийн төсөлд тусгах шаардлагатай.

Хөгжлийн сангийн ил тод байдал

Хөгжлийн сангийн ил тод байдлыг дараах байдлаар ангилан олон нийтэд нээлттэй мэдээлэх механизмыг хуулийн төсөлд тусгаж өгөх шаардлагатай.

- *Үйл ажиллагааны ил тод байдал:* Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч компани (төрийн өмчит ХХК), Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагааны ил тод байдал;
- *Хяналт, түүний үр дүнгийн ил тод байдал:* Хөндлөнгийн аудитын дүгнэлт, эрх бүхий бусад байгууллагын хяналт, шалгалтын тайлангийн ил тод байдал;
- *Удирдлага, албан тушаалтны мэдээллийн ил тод байдал:* Ашиг сонирхлын хамаарлын мэдээллийн ил тод байдал.

Санал: Хөгжлийн сангийн ил тод байдал, тайлагналыг ямар байдлаар хэрхэн хэрэгжүүлэх тухай зохицуулалтыг боловсруулахдаа олон улсад баялгийн сангийн ил тод байдлыг үнэлдэг “Linaburg-Maduell Transparency” индексийг харгалзан үзэж болох юм. Тус индекс нь баялгийн сангуудын мэдээллийн ил тод байдлыг 10 шалгуур үзүүлэлтээр тус бүрд нь нэг оноо өгч дүгнэдэг байна.

“Linaburg-Maduell” ил тод байдлын индексийн зарчим²

Оноо	Ил тод байдлын зарчим
+1	Сан байгуулсан огноо, зорилго, хөрөнгийн эх үүсвэр, төрийн өмчийн бүтцийн мэдээллийн нээлттэй байдал
+1	Сангийн өмнөх ба одоог хүртэл хийлгэсэн хөндлөнгийн аудитын дүгнэлтийн ил тод байдал
+1	Сангийн бусад компани дахь эзэмшлийн хувь, тухайн компанийн үйл ажиллагаа явуулдаг газрын байршлын ил тод байдал
+1	Сангийн хөрөнгө оруулалтын нийт хэмжээ, түүний өгөөж, удирдлагын зардлын ил тод байдал
+1	Сан, хөрөнгө оруулалтын бодлогод тулгуурлан ёс зүйн дүрмийг тодорхойлсон байдал, хэрэгжилтийн ил тод байдал
+1	Сангийн стратеги ба үндсэн зорилтуудын тайлбар мэдээллийн ил тод байдал
+1	Боломжтой тохиолдолд сантай холбоотой бусад байгууллага (охин, хараат компани), тэдгээрийн холбоо барих мэдээллийг нээлттэй болгосон байдал
+1	Боломжтой тохиолдолд сангийн удирдлагад байх гадаад удирдлагын мэдээллийг нээлттэй болгосон байдал
+1	Сан өөрийн цахим хуудсыг хөтлөн явуулдаг байх
+1	Сангийн үндсэн байршил, хаяг, холбогдох утас, факс зэрэг мэдээллийн ил тод байдал

ХОЁР. ТУСГАЙ САНАЛ, ШҮҮМЖ

№	Хуулийн төсөлд зүйл, заалт нэмэх, өөрчлөх	Үндэслэл (тайлбар)
1	4.1.2-т “...эрх бүхий этгээдээс баталсан...” гэдгийг “... хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан...” гэж өөрчлөх	Хуулийн төслийн 12.1 болон 14.1 дэх заалтын агуулгад нийцүүлэх нь зүйтэй.
2	4.1.4-т “... хүү...” гэдэг үгийг хасах	Хөгжлийн сангийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төрлүүдэд хүүгийн ашиг олох боломжтой үйл ажиллагаа тусгагдаагүй тул хасах нь зүйтэй.
3	5.1-ийг “Хөгжлийн сангийн хөрөнгийн удирдлагыг хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан мандатын дагуу төрийн өмчит ХХК хэрэгжүүлнэ” гэж өөрчлөх	Хөгжлийн санг түүний хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх компаниас салган тодорхойлох шаардлагатай.
4	5.4-ийг “Хөгжлийн сан нь хөрөнгө оруулалт хийсэн хуулийн этгээдийн өр төлбөрт хувьцаа эзэмшигчийн эсхүл хөрөнгө оруулагчийн хувиар ямар нэгэн хариуцлага хүлээхгүй ба хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж буй этгээд хариуцлага хүлээнэ” гэж өөрчлөх	Хөгжлийн сангийн хөрөнгийг хөрөнгө оруулалт хийсэн хуулийн этгээд болон түүний охин, хараат компанийн хөрөнгөөс тусгаарлах зохицуулалтыг тусгаж өгснөөр дээрх зохицуулалт хэрэгжих боломжтой.

² “Linaburg-Maduell” ил тод байдлын индексийн зарчмыг <http://www.swfinstitute.org/research/linaburg-maduell-transparency-index> цахим хуудаснаас үзнэ үү.

№	Хуулийн төсөлд зүйл, заалт нэмэх, өөрчлөх	Үндэслэл (тайлбар)
5	Хуулийн төслийн 6 дугаар зүйлд “Хөгжлийн сангийн өөрийн хөрөнгө” гэдгийг “Хөгжлийн сангийн хөрөнгө” гэж өөрчлөх	4.1.1 дэх заалтын агуулгатай нийцүүлэх шаардлагатай. Хуулийн төслийн 6 дугаар зүйл болон 4.1.1 дэх заалтууд хоёр тусдаа хөрөнгийн хэлбэртэй мэт төөрөгдөл үүсгэхүйц томъёологдсон байх ба Хөгжлийн сангийн хөрөнгө, Хөгжлийн сангийн өөрийн хөрөнгийн тодорхойлолт утгатай байна.
6	8.1.1-д “... аливаа хэлбэрээр нөлөөлөхгүй, зааварчилгаа өгөхгүй...” гэж нэмэх	Хөгжлийн сангийн үйл ажиллагаанд нөлөөлж болох бүх хэлбэрийг багтааж тодорхойлох шаардлагатай.
7	8.1.2-т “... зааснаар Хөгжлийн сангийн төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах...” гэж нэмэх	Ямар субъектийг сонгох шалгаруулах, томилох, гэрээ байгуулахыг тодорхой болгох шаардлагатай.
8	8.1.3-ыг “Хөгжлийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд аливаа хэлбэрээр бусдын нөлөөнд автахгүй, хараат бус, бие даасан байх” гэж өөрчлөх	Найруулгыг сайжруулах.
9	8.1.5-д “... зах зээлийн өрсөлдөхүйц...” гэж нэмэх	Холбогдох заалтын агуулгыг тодорхой болгох.
10	8.3.7-д “Сангийн хөрөнгийг энэ хуульд зааснаас бусад хэлбэрээр зориулалтын бусаар ашиглахгүй байх”	Хөгжлийн сангийн хөрөнгийг зохистой удирдахад баримтлах зарчмыг тусгах шаардлагатай.
11	8.3.5-ыг “Хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч болон хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэгч бусад этгээдийн бусдын өмнө хүлээсэн үүргийг сангийн хөрөнгөөр хүлээхгүй байх” гэж өөрчлөх	Хөрөнгийн удирдлага хэрэгжүүлэгчийн бусдын өмнө хүлээсэн үүргийг Хөгжлийн сангийн хөрөнгөөр хариуцах явдлаас сэргийлэх.
12	8.4.3-т “Сангийн үйл ажиллагаа нь төсөв, санхүү, макро эдийн засаг болон мөнгөний бодлоготой уялдсан байх”; 8.4.4-т “Сангийн хөрөнгийг хуульд өөрөөр заагаагүй бол зарцуулахгүй байх”; 8.4.5-д “Сангийн хөрөнгийг удирдах үйл ажиллагаа нь дотоод болон хөндлөнгийн хяналттай байх”; 8.4.2-т “Сангийн хөрөнгийг удирдах үйл ажиллагаа нь тогтвортой урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурласан байх” гэсэн заалт нэмэх.	Сангийн үйл ажиллагаанд баримтлах зарчмуудыг тодорхой болгож, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдэнэ.
13	8.5.4-ийг “Хөгжлийн сангийн ногдол ашгийг хуримтлуулах зорилгоор зөвхөн Ирээдүйн өв санд шилжүүлнэ” гэж өөрчлөх.	Ногдол ашиг хуваарилах шийдвэр гарсан тохиолдолд ногдол ашгийг зөвхөн Ирээдүйн өв сан авах эрхтэй байх зохицуулалт тусгах шаардлагатай. Нийт иргэнд ногдол ашиг тараах асуудлыг гагцхүү хууль батлах замаар шийдвэрлэдэг байх нь зүйтэй.
14	9.1.6-д “Хуульд заасан бусад орлого” гэж нэмэх	Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас хамааран үл хөдлөх хөрөнгийн түрээсийн орлого, шимтгэл, төлбөр гэх мэт олон орлого байх боломжтой.
15	12.2-ыг “Мандатын хэрэгжилтэд Төлөөлөн Удирдах зөвлөл хяналт тавьж, хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана” гэж өөрчлөх.	Компанийн засаглалын зарчимд нийцүүлэх.

№	Хуулийн төсөлд зүйл, заалт нэмэх, өөрчлөх	Үндэслэл (тайлбар)
16	12.3.1-ийг “хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үндсэн зорилго, чиглэл” гэдгийг “өгөөжийн зорилгот түвшин” гэж өөрчлөх.	
17	13.1-ийг “Гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигчдээс баталсан мандатын дагуу хөрөнгө оруулалтын стратегийн төслийг боловсруулж, төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж батлуулна” гэж өөрчлөх.	Компанийн засаглалын зарчимд нийцүүлэх.
18	Хуулийн төслийн 13.5 болон 13.6 дахь заалтуудын дэс дарааллыг өөрчлөх.	
19	16.1.12-т “Хөгжлийн сангийн мандатыг хэрэгжүүлэх хөндлөнгийн хөрөнгө оруулалтын менежментийн компани...” гэж нэмэх.	
20	20.10-т “...багийн ахлагчийг төлөөлөн удирдах зөвлөлөөс томилж, Хөгжлийн сангийн гүйцэтгэх захирлын үүргийг гүйцэтгэнэ” гэж өөрчлөх.	
21	20.16.12-ыг “энэ хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу Хөгжлийн сангийн ил тод байдлыг ханган ажиллах” гэж өөрчлөх.	Хуулийн төслийн 20 дугаар зүйлд Хөгжлийн сангийн ил тод байдалтай холбоотой зохицуулалтыг тусгаагүй байна.
22	20.14-ийг “Төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээг дараах нөхцөлд цуцалж болно” гэж өөрчлөх. Мөн 20.14.1-д “Хөрөнгө оруулалтын стратегийг хангалтгүй биелүүлсэн нь хөндлөнгийн хяналтын байгууллагаас тогтоогдсон”; 20.14.2-т “Гүйцэтгэх удирдлага болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн”; 20.14.3-т “гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон”; 20.14.4-т “Дээрх нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд гүйцэтгэх удирдлага болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийг хугацаанаас нь өмнө чөлөөлөхийг хориглоно” гэж нэмэх.	Хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.14 болон 20.19 дэх заалтын агуулгыг нэгтгэж, 20.14 дэх заалтыг өөрчлөн найруулах нь илүү оновчтой байна.
23	22.1.3-т “хуульд заасан хэмжээгээр хөрөнгө оруулалтын цэвэр ашиг, хувьцаа эзэмшлийн ногдол ашгийг Ирээдүйн өв санд шилжүүлэх” гэсэн заалт нэмэх.	
24	23.1.9-д “Хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийг аливаа хэлбэрээр дотоодын арилжааны банканд байршуулахыг хориглоно” гэж нэмэх.	Хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийг хадгалах, хуримтлуулах үед гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор уг төрлийн үйл ажиллагааг хориглох шаардлагатай.
25	25.1-ийг “Хөгжлийн сангийн хөрөнгө оруулсан хуулийн этгээд нь үйл ажиллагаандаа сайн засаглалын зарчмыг дагаж мөрдөх” гэж өөрчлөх.	

Хуулийн шүүмжийг боловсруулсан:
Хууль зүйн доктор, М.Түвшинжаргал (Ph.D., Erciyes),
ННФ-ын Төсвийн зөвлөл



Жамъян гүний гудамж-5/1
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар-14240
Монгол Улс
Утас: (976) 76113207
Вэб: www.forum.mn
И-мэйл: osf@forum.mn